

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатын дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалагдах эрхтэй..." гэж, Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтад "Түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаахыг хориглоно" гэж, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.4.2.-т "Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана" гэж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолын 3.-т "Боловсруулсан түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх..." гэж, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 15/12 дугаар тогтоолд "Сайжруулсан хатуу түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх, түлшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор сайжруулсан хатуу түлшний нэг тонн тутмын үнийг 150,000 /Нэг зуун тавин мянган/ төгрөгөөр, ... тус тус тогтоосугай" гэж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд "Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сайжруулсан шахмал түлшний борлуулалтын орлогыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд уг асуудлыг 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх..." гэж тус тус заасан заалтууд нь хуулийн төсөл боловсруулах үндэслэл болно.

Сүүлийн жилүүдэд нийслэлд хотжилт, үйлдвэржилт, хүн амын хэт төвлөрөл зэрэг хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хүрээлэн байгаа орчин, хөрс, агаарын бохирдол хүлцэшгүй хэмжээнд хүрч, улмаар амьсгалын зам, зүрх судас, төв мэдрэлийн системүүдийн өвчлөл, харшил, хавдар зэрэг өвчинүүдийн тархалт жилээс жилд ихсэн бага насны хүүхэд, өндөр настнуудын эрүүл мэндэд ноцтой хохирол, аюулыг бодитойгоор учруулж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжээ байх ёстой хэмжээнээс даруй 100 гаруй дахин нэмэгдэж, дэлхийн агаарын бохирдол ихтэй 10 хотын нэгээр бүртгэгдсэн асуудлыг Монгол Улсын төр засаг үндэсний аюулгүй байдлын хэмжээнд авч үзэж байна.

Монгол Улсын эрүүл мэндийн зардал жил бүр 4.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж нийгэмд учруулах хор хохирол 4.1 их наяд төгрөгт хүрсэн гэх тооцоог Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан. Мөн эрүүл мэндийн салбарын зардлын өсөлт нь улс орнуудын ядуурлын гол үндэс суурь болдог бөгөөд 2025 он гэхэд жилд 12 мянган хүн нүүрсний утаанаас үүдэлтэй амьсгалын зам, зүрх судас, хавдарын өвчин

эмгэгээр нас барахаас гадна эдийн засгийн ихээхэн зардал гарна гэсэн дүгнэлтийг Олон улсын Эрүүл мэндийн байгууллага, АШУУИС-ийн эрдэмтдийн хамтарсан баг хийсэн байна.

Нийслэлийн статистикийн газрын 2017 оны мэдээгээр Улаанбаатар хотод 215,156 өрх гэр хороололд амьдарч байгаагаас 201,474 нь Засгийн Газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийн бус нутагт амьдарч байна.

Дэлхийн банкны судалгаагаар нэг өрхийн халаалтын улирлын түүхий нүүрсний дундаж хэрэглээ 4-6 тн гэж гарсан бөгөөд жилийн нийт хэрэглээ 1,200,000 тн байгааг, "Таван толгой түлш" ХХК байгуулагдан бүтээгдхүүнээ зах зээлд нийлүүлж эхэлсэнээр 201,474 өрхийн түлшний хэрэглээг 600,000 гаруй тн болгон бууруулах боломж анх удаа бий болж байна.

Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын орлогод ноогдох НӨАТ-ыг хөнгөлснөөр 1 тонн сайжруулсан шахмал түлшний иргэдийн гар дээр очих үнэ 15,000 /арван таван мянга/ төгрөгөөр буурах боломжтой. Улаанбаатар хотын нийт гэр хорооллын түлшний хэрэглээ 600,000 /зургаан зуун мянган/ тонн гэж үзвэл нийт шахмал түлшний борлуулалтанд ноогдох НӨАТ 9 тэрбум төгрөг болно.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан "Таван толгой түлш" ХХК нь сайжруулсан шахмал түлшийг хямд өртгөөр үйлдвэрлэн, иргэдийн хэрэгцээнд нийлүүлснээр Улаанбаатар хотын түүхий нүүрсний хэрэглээг халж, түлшний биет хэмжээг 40-50 хувиар багасгаж, агаарын бохирдлыг 30-50 хувиар бууруулна гэсэн судалгааг Япон улсын "Жайка" байгууллага хийгээд байна.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ:

Тандан судалгааны ажил болон хуулийн төсөл боловсруулах хүрээнд Эрчим хүчний яам, "Таван толгой түлш" ХХК-иас тоон мэдээлэл цуглуулах, тодорхой тохиолдлыг судлах хэлбэрээр чанарын мэдээлэл цуглуулсан болно.

Уг хууль "Таван толгой түлш" ХХК-ийн үйлдвэрлэсэн сайжруулсан түлшийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх бөгөөд энэхүү хуулийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөхөөр зохицуулсан.

"Таван толгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөд нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгжийн хууль ёсны ашиг, сонирхолд сөрөг үр нөлөө үзүүлэхгүй болно.

1.2. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох.

Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор түүхий нүүрс хэрэглэхийг хориглож, боловсруулсан түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх, түлшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах асуудлыг судалж шийдвэрлэхийг тус тус үүрэг болгосон.

Үүний дагуу Засгийн газрын 2018 оны 387 дугаар тогтоолоор сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх үүрэг бүхий төрийн өмчит "Таван толгой түлш" ХХК-ийг байгуулан ажиллаж байна.

Одоогийн байдлаар тус компани нь өдөрт 2,300-2,900 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, цаашид үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж өдөрт 3500 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөж байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 19/12 дугаар тогтоолоор сайжруулсан хатуу түлшний үнийг түүхий нүурсний үнээс хэтрүүлэхгүй байх, түлшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор сайжруулсан хатуу түлшний нэг тонн тутмын үнийг 150,000 төгрөгөөр тогтоосон.

Гэвч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нэмэгдсэн өртгийн албан татвар тооцсон өртгөөр борлуулахад 1 тонн нь 165 мянган төгрөг буюу 1 тонн тутамд 15 мянган төгрөг нэмэгдэхээр байгаа нь гэр хорооллын өрхийн худалдан авах чадварыг бууруулах, улмаар амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Сайжруулсан шахмал түлшийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж, хямд түлшээр иргэдийг хангаснаар Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулахад төрөөс үзүүлж байгаа бодит дэмжлэгийн нэг болох юм.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулж, агаарын чанарыг сайжруулах зорилгоор "Таван толгой түлш" ХХК-ийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчин бүрдэнэ.

Сайжруулсан шахмал түлшийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлснөөр гэр хорооллын бага орлоготой иргэдийн өрхийн зардалд түлшний үнийн нөлөөлөл буурч, сайжруулсан шахмал түлшний хэрэглээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулахад бодитой дэмжлэг болох юм.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

3.1. Зохицуулалтын хувилбарууд:

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргав:

Хувилбар		Харьцуулалт		Үр дүн
	Эерэг	Сөрөг		
1	Тэг хувилбар		Сайжруулсан шахмал түлшний үнэ нэмэгдэнэ	Сөрөг үр дүнтэй
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх нь санхүүгийн дарамтаас чөлөөлөхөд чиглэгдсэн тул соён гэгээрүүлэх ажил шаардлагагүй.	Сөрөг үр дагаваргүй	Үр дүнгүй
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудалд төрийн дэмжлэг шаардлагатай.	Сөрөг үр дагаваргүй	Үр дүнтэй.

4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Бүтээгдэхүүний үний хямдруулах боломжтой.	Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж санхүүжилт хийх боломжгүй. Улсын төсөвт нэмэлт зардал бий болно.	Үр дүн багатай.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;		Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөд төрийн бус байгууллага оролцох боломжгүй	Үр дүнгүй
6	Захиргааны шийдвэр гаргах		Эрх олгосон заалт байхгүй учраас Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3-т заасан шийдвэр гаргаж, зохицуулах боломжгүй.	Үр дүнгүй
7	Хууль тогтоомжийн тесөл боловсруулах	Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй.” Гэж заасан тул Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль тогтоомжийн тесөл боловсруулах шаардлагатай байна.		Өндөр үр дүнтэй гэж үзэж байна.

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн эерэг сөрөг талаас нь үнэлэхэд хувилбар 7 нь тулгамдаж байгаа асуудлыг хамгийн үр дүнтэйгээр шийдвэрлэж чадах хувилбар болох нь тандан судалгаагаар тогтоогдож байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлөх асуудлыг хуулиар шийдвэрлүүлэхээр холбогдох хуульд заасан тул цаашид хувилбар 7 буюу “Хууль тогтоомжийн тесөл боловсруулах” гэсэн зохицуулалтын хувилбар болгон үргэлжлүүлэн судлах нь зүйтэй гэж үзлээ.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫГ ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийн нэгтгэн гаргав.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралтын хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Тус хууль нь хүний эрхийн зөрчил, хүний эрхийг хязгаарласан мөн жендерийн тэгш байдлыг зөрчих зохицуулалт агуулаагүй, тэгш хандлагатай.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 19/12 дугаар тогтоолоор сайжруулсан хатуу түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх, түлшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор сайжруулсан хатуу түлшний нэг тонн тутмын үнийг 150,000 төгрөгөөр тогтоосон.

Гэвч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нэмэгдсэн өргтгийн албан татвар тооцсон өргтгөөр борлуулахад 1 тонн нь 165 мянган төгрөг буюу 1 тонн тутамд 15 мянган төгрөг нэмэгдэхээр байгаа нь гэр хорооллын өрхийн худалдан авах чадварыг бууруулах, улмаар амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлнө.

Сайжруулсан шахмал түлшний борлуулалт нь шинээр эхэлж байгаа бөгөөд борлуулалтын орлогод ноогдох нэмэгдсэн өргтгийн албан татварыг өмнө нь төсөвт хураан авч төвлөрүүлж байгаагүй тул үүнийг чөлөөлснөөр төсвийн орлогод нөлөө үзүүлэхгүй юм.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Энэхүү хууль батлагдсанаар гэр хорооллын бага орлоготой иргэдийн өрхийн зардалд түлшний үнийн нөлөөлөл буурч, сайжруулсан шахмал түлшний хэрэглээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлснээр агаарын бохирдол буурч, иргэдийн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Агаар орчны бохирдлыг бууруулахад чухал ач холбогдолтой. Хүрээлэн буй орчинд нөлөөлж байгалийн унаган төрхийг эвдэж доройтуулах, ус, хөрс, агаарыг бохирдуулах үйлчлэл үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалагдах эрхтэй..." гэж, Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтад "Түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаахыг хориглоно" гэж, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.4.2.-т "Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана" гэж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолын 3.-т "Боловсруулсан түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх..." гэж, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 15/12 дугаар тогтоолд "Сайжруулсан хатуу түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх, түлшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор сайжруулсан хатуу түлшний нэг тонн тутмын үнийг 150,000 /Нэг зуун тавин мянган/ төгрөгөөр, ... тус тус тогтоосугай" гэж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд "Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сайжруулсан шахмал түлшийг нэмэгдсэн өргтгийн албан татвараас чөлөөлөх тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд уг асуудлыг 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх..." гэж тус тус заасантай нийцэж байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд болон бусад хууль тогтоомжуудтай нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл боловсруулахгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг:

- Зорилгод хүрэх байдал
- Зардал, үр өгөөжийн харьцаа
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх
- Гарч болох сөрөг үр дагавар, түүний арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг хуулиар шийдвэрлэхээр холбогдох хуульд заасан тул цаашид хувилбар 7 буюу "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн зохицуулалтын хувилбар болгон үргэлжлүүлэн судлах нь зүйтэй гэж үзлээ.

"Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн зохицуулалтын хувилбар нь дэвшүүлсэн зорилгод бүрэн хүрэх боломжтой ба энэ нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээний агуулга, зарчимд нийцнэ гэж дүгнэж байна.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Тандан судалгааны өмнөх шатанд дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд хувилбар 7 буюу "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн зохицуулалтын хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзлээ.

Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй" гэж заасан тул нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай "хууль тогтоомжийн төсөл боловсруулах" шаардлагатай болно.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбар нь одоогийн нөхцөлд дэвшүүлсэн зорилгыг хангах хамгийн боломжит хувилбар бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь байж болох хэмжээнээс хэтрэхгүй болно.

Энэ хууль батлагдсанаар гэр хорооллын бага орлоготой иргэдийн өрхийн зардалд түлшний үнийн нөлөөлөл буурч, сайжруулсан шахмал түлшний хэрэглээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлснээр агаарын бохирдол буурч, иргэдийн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлнэ.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Хавсралт

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Энэ чиглэлээр хуулийн төсөлд шинээр заалт тусгагдахгүй.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Аль нэг бүлэгт давуу байдал үүсгэхгүй.
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бурдуулсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Иргэдэд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хуульд зохицуулалт тусгаагүй. ийм
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хуульд зохицуулалт тусгаагүй. ийм
2. Хүний эрхийг	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь	Тийм	Үгүй	Ийм зохицуулалт байхгүй.

хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	хууль ёсны зорилгод нийцсэн эсэх			
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Ийм зохицуулалт байхгүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгж
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ийм зохицуулалт байхгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Хамаарахгүй.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	хамаарахгүй
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамаарахгүй

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэхгүй.

	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэхэд нөлөө үзүүлэхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	хамаарахгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	хамаарахгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл ийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гарахгүй, зардлыг бууруулна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (ул хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх			
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Иноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Компани судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээгдэхүүн гаргах асуудлыг дэмжинэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг дэмжих боломж бүрдэнэ.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3. Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсөвт ачаалал болохгүй.
	9.2. Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт			
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдол тодорхой хувиар буурснаар амьсгалын замын өвчлөл буурах эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдол буурна.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сергээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.3.АН АМЫТДЫН НҮҮДЭЛ, СУУРЬШИЛД СЕРГӨӨР НӨЛӨӨЛӨХ ЭСЭХ	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдуулэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохицой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

---Оо---